



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Жадамбын БАТ-ЭРДЭНЭ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-27-40, Факс: 32-70-16  
E-mail: batedenej@parliament.mn  
http://www.parliament.mn

2023.06.20 № ЗУХ-03/5519  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Иймд хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Ж.БАТ-ЭРДЭНЭ

Н.ГАНИБАЛ

Л.МӨНХБААТАР

Г.ТЭМҮҮЛЭН

Ч.УНДРАМ

0000000254



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Жадамбын БАТ-ЭРДЭНЭ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-27-40, Факс: 32-70-16  
E-mail: batedenej@parliament.mn  
http://www.parliament.mn

2022.11.17 № УИХ-03/11048

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Тов тогтоолгох тухай Г

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Иймд хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт ~~21~~ хуудастай

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Ж.БАТ-ЭРДЭНЭ

0000000554



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 08 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар ХТТ/1828

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Ж.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Хуралдааны тэмдэглэл  
хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн санаачлан боловсруулсан Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт... хуудас.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



  
Ц.НЯМДОРЖ

000225008223

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэлд:

“Ү.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн санаачлан боловсруулсан Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн санаачлан боловсруулсан Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцаад дараахь үндэслэлээр дэмжих боломжгүй байна. Үүнд:

1. Хуулийн төсөлд иргэн нь эзэмшиж байгаа өвөлжөө, хаваржааны газраас 200 метрийн радиуст төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тариалах зориулалтаар 1.0 га хүртэл газрыг эзэмшүүлэхээр заасан нь газрын талаарх төрийн нэгдмэл бодлого болон Газрын тухай хуулийн 4.1.1-д “Монгол Улсын газар нутаг салшгүй бүрэн бүтэн, газрын сан нэгдмэл байх” гэж, 4.1.3-т “газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах” гэж заасан зарчимд нийцэхгүй байна.

Өөрөөр хэлбэл, газартай холбоотой аливаа үйл ажиллагаа нь эрх бүхий мэргэжлийн байгууллагаас боловсруулсан улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүнд үндэслэсэн аймаг, сумдын газар зохион байгуулалтын төлөвлөлтөд үндэслэх шаардлагатай.

Харин хуулийн төсөлд өвөлжөө, хаваржааны газраас 200 метрийн радиуст хүнсний ногоо тариалах зориулалтаар газар эзэмшүүлэхээр заасан нь Газрын тухай хуульд “төрөөс тусгайлан тогтоосон, газрын нэгдмэл сангийн ангиллаар зөвхөн тариалангийн талбайд бүртгэлтэй газраас иргэдэд эзэмшүүлэх”-ээр зохицуулсан бодлогыг алдагдуулах, уг газрыг малчид цаашид зориулалтын дагуу тогтвортой ашиглахгүй тохиолдолд газрыг атаршуулах, хөрс доройтуулах, бэлчээр болон тариалангийн газартай холбоотой зөрчил, маргаан нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавар үүсэх эрсдэлтэй байна.

2. Газрын тухай хуулийн 29.2-т “иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 0.1 га-гаас илүүгүй газар үнэ төлбөргүй эзэмшүүлж болно” гэж, 29.3-т “Багийн иргэдийн Нийтийн Хурлын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн, тариалангийн газрыг газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан Засгийн газраас тогтоосон журмын дагуу давуу эрхээр эзэмшүүлж болно. Нэг иргэнд давуу эрхээр эзэмшүүлэх тариалангийн газрын хэмжээ нь үр тарианы зориулалтаар 100 га хүртэл, төмс, хүнсний ногооны зориулалтаар 5 га хүртэл байна.” гэж заасан.


Өөрөөр хэлбэл, Газрын тухай хуулиар иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 0.1 га хүртэл газрыг үнэ төлбөргүй эзэмшүүлж болохоор

зохицуулсан бөгөөд иргэний үнэгүй эзэмших газар нь хувийн гэр, орон сууцны хашааны газрын зэргэлдээ, эсхүл уг зориулалтаар тусгайлан тогтоогдсон газарт байж болох зохицуулалт Газрын тухай хуулиар нээлттэй.

Хуулийн төсөлд зөвхөн өвөлжөө, хаваржааны газар эзэмшигчид 1.0 га хүртэл газрыг дээрх зориулалтаар эзэмшүүлэхээр тусгасан нь Газрын тухай хуулийн 4.1.3-т заасан “газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах зарчим”-д нийцэхгүй, мөн хуулийн 54.1-д “Энэ хуулийн 29.2, 29.3, 29.5-д зааснаас бусад тохиолдолд шинээр тариалангийн талбай бий болгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ” гэж заасантай зөрчилдөж байна.


3. Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 7 дугаар сарын 6-ны өдөр баталсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай” тогтоолд тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх, тариалангийн газрыг улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулахыг Засгийн газарт үүрэг болгосон.

Иймд тус тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газраас тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.  
МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ГИШҮҮН**



**Ж.БАТ-ЭРДЭНЭ**

**ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага.**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 8.3 дахь зорилтын хүрээнд 2021-2030 онд “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээс хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулж, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангана.” гэж, 2031-2040 онд “Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гадаад зах зээлийг тэлж, зарим нэр төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний импортыг халж, экспортыг нэмэгдүүлнэ.”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 8.3.1-т “гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3-т “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.” гэж тус тус заасан.

Хөдөө аж ахуйн газар нь манай орны газар ашиглалтын уламжлалтай холбоотойгоор газрын нэгдмэл сангийн дийлэнхи хэсгийг эзлэх боловч сүүлийн жилүүдэд гарч буй газар ашиглалтын хэлбэр, зориулалт нэмэгдэж байгаатай уялдан түүний хэмжээ ялангуяа бэлчээрийн талбайн хэмжээ байнга буурсаар байна.

Хөдөө аж ахуйн зориулалтай 119,254,221 га талбай байгаагаас бэлчээрийн талбай 116,627,574 га /97%/, хадлангийн талбай 634,505 га /0,0005%/, тариалангийн талбай 1,171,512 га /0,009%/, атаршсан газар 238,832 га /0,002%/, хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр газар 106,339 га, ашиглалт муутай газар 475,456 га /0,003%/, байна.

Газрын нэгдмэл сангийн 2021 оны улсын нэгдсэн тайланд дурдсанаар улсын хэмжээнд 80,033 га талбай бүхий өвөлжөө, хаваржааны газрыг 137,914 иргэн эзэмшиж байна.

Тариаланд ашиглаж буй нийт талбайн хөрсний 36.2 хувь нь элсэнцэр, 53.0 хувь нь хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна. Хөнгөн механик бүрэлдэхүүнтэй хөрсөнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэхдээ

хөрс хамгаалах технологийг иж бүрэн хэрэгжүүлээгүйгээс элэгдэж эвдрэлд тариалангийн газрын хөрсний ялзмаг агуулалт нийтдээ ядуу бөгөөд хөрсний элэгдэл эвдрэлд нэрвэгдсэнээр ялзмаг агуулалтынхаа 7.2-39.4 хувийг алдсан байна.

Бэлчээрийн мониторингийн 2016 оны мэдээллээр, мониторингийн бүх цэгийн 42 хувь нь төлөв байдлын хувьд "соргог" буюу "талхлагдаагүй", 13,5 хувь нь сул, 21,1 хувь нь дунд зэрэг, 12,8 хувь хүчтэй талхлагдсан, харин 1,3 хувь нь сэргэлтгүй талхлагдсан бөгөөд тайлангийн суурь он буюу 2014 оныхтой харьцуулбал, бэлчээрийн талхлагдлын түвшин сүүлийн 2 жил өссөн дүнтэй, талхлагдаагүй болон сул талхлагдсан гэж ангилагдсан цэгийн тоо 10 хувь буурч, хүчтэй болон сэргэлтгүй талхлагдсан цэг 4,3-5,9 хувиар тус тус нэмэгдсэн гэж тогтоогджээ.

Орчин үед газрыг зохистой ашиглах асуудал хөдөө аж ахуйн газрын экологийн төлөв байдал, түүнтэй нягт холбоотой ашиглалт, хамгаалалт, үнэлгээний асуудал ихэнхдээ ургамлан нөмрөгийнх нь талхлагдал, хөрсөн бүрхэвчийнх нь элэгдэл эвдрэл буюу газрын доройтлоор тодорхойлогдож байна.

2002 онд батлагдсан Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлд "Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар 0,07 га-гаас илүүгүй, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 0,1 га-гаас илүүгүй газар үнэ төлбөргүй эзэмшүүлж болно", "Багийн иргэдийн нийтийн хурлын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрийг үндэслэн, тариалангийн газрыг газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан Засгийн газраас тогтоосон журмын дагуу давуу эрхээр эзэмшүүлж болно. Нэг иргэнд давуу эрхээр эзэмшүүлэх тариалангийн газрын хэмжээ нь үр тарианы зориулалтаар 100 га хүртэл, төмс, хүнсний ногооны зориулалтаар 5 га хүртэл байна" гэж тус тус заасан байдаг.

Дээрх хуулийн заалтаас үзэхэд иргэнд төмс, хүнсний ногоо, таримал ургамалын зориулалтаар олгогдох газрын хэмжээ 0,1 га-гаас илүүгүй байх бөгөөд зөвхөн газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэн 0,1 га-гаас илүү хэмжээгээр үнэ төлбөргүй газар эзэмших эрхтэй байна. Өөрөөр хэлбэл иргэн газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажиллагаагүй бол 0,1 га-гаас илүү хэмжээгээр газар үнэ төлбөргүй эзэмших эрхгүй юм.

Мөн Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дах хэсэгт заасны дагуу атар газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглосон тул сум, орон нутгийн иргэдэд төмс, хүнсний ногоо, таримал ургамал тарих зориулалтаар эзэмшүүлэх эрх зүйн зохицуулалт нь учир дутагдалтай байна.

Хөдөө аж ахуйн газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бэлчээрийн доройтол, хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, иргэдийн амьдралын түвшинг сайжруулахын тулд энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

**Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу боловсруулсан бөгөөд дараах зохицуулалтыг тусгалалаа.

1. Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан нэг удаа үнэ төлбөргүй эзэмшүүлэх газрын хэмжээ хувийн гэр, орон сууцны зориулалтаар 0,07 га, өвөлжөө, хаваржааны зориулалтаар 1,5 га-аас тус тус илүүгүй байна
2. Өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмшиж буй иргэн эзэмшлийн газартаа гэр бүлийн хэрэгцээндээ зориулж төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тариалж болно.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар үүсч болох улс төр, нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах эерэг үр дүнд хүрнэ.

1. Газар нутгийн экологийн төлөв байдлын өөрчлөлтөөс шалтгаалж бэлчээрийн болон тариалангийн газрыг ашиглаж ирсэн уламжлалт арга ажиллагааг явуулах боломж нээгдэнэ.
2. Хөдөө аж ахуйн газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулахын тулд өвөлжөө, хаваржааны газартаа иргэд төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих эрх зүйн орчин бүрдэнэ.
3. Хөрсний үржил шимийг шавхан дайчлах, ургамлан нөмрөгийг талхлагдал оруулдаг газар ашиглалтыг хөрсний үржил шимийг нөхөн сэргээх, хамгаалах ашиглалт сайжирна.
4. Хөдөө орон нутгийн иргэд, ялангуяа малчид төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарьснаар бэлчээрийн доройтол буурч, иргэдийн амьжиргаа сайжирах нөхцөл бүрдэнэ.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хэрэгжүүлэх талаар цаашид шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар санал**

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай бүрэн нийцэж байгаа болно. Хуулийн төсөлтэй холбогдуулан Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулна.

**ХУУЛЬ САНААЧЛАГЧ**



## ТАНИЛЦУУЛГА

*“Газрын тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай”  
Хуулийн төслийн талаар*

Хөдөө аж ахуйн газар нь манай орны газар ашиглалтын уламжлалтай холбоотойгоор газрын нэгдмэл сангийн дийлэнхи хэсгийг эзлэх боловч сүүлийн жилүүдэд гарч буй газар ашиглалтын хэлбэр, зориулалт нэмэгдэж байгаатай уялдан түүний хэмжээ ялангуяа бэлчээрийн талбайн хэмжээ байнга буурсаар байна. Манай орны хөдөө аж ахуйн газрын хэмжээ сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд ойролцоогоор 15.0 орчим сая.га-аар буурсан байна. Хөдөө аж ахуйн газар нь байгалийн унаган төрх байдал, нөөц чавахиаараа харилцан адилгүй тул хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд гүйцэтгэх үүргээр нь бэлчээрийн газар, тариалангийн газар, хадлангийн газар, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар гэж хуваагддаг.

Хөдөө аж ахуйн зориулалтай 119,254,221 га талбай байгаагаас бэлчээрийн талбай 116,627,574 га /97%/, хадлангийн талбай 634,505 га /0,0005%/, тариалангийн талбай 1,171,512 га /0,009%/, атаршсан газар 238,832 га /0,002%/, хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр газар 106,339 га, ашиглалт муутай газар 475,456 га /0,003%/, байна.

Газрын нэгдмэл сангийн 2021 оны улсын нэгдсэн тайланд дурдсанаар улсын хэмжээнд 80,033 га талбай бүхий өвөлжөө, хаваржааны газрыг 137,914 иргэн эзэмшиж байна.

Тариаланд ашиглаж буй нийт талбайн хөрсний 36.2 хувь нь элсэнцэр, 53.0 хувь нь хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна. Хөнгөн механик бүрэлдэхүүнтэй хөрсөнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэхдээ хөрс хамгаалах технологийг иж бүрэн хэрэгжүүлээгүйгээс элэгдэж эвдрэлд тариалангийн газрын хөрсний ялзмаг агуулалт нийтдээ ядуу бөгөөд хөрсний элэгдэл эвдрэлд нэрвэгдсэнээр ялзмаг агуулалтынхаа 7.2-39.4 хувийг алдсан байна.

Бэлчээрийн мониторингийн 2016 оны мэдээллээр, мониторингийн бүх цэгийн 42 хувь нь төлөв байдлын хувьд “соргог” буюу “талхлагдаагүй”, 13,5 хувь нь сул, 21,1 хувь нь дунд зэрэг, 12,8 хувь хүчтэй талхлагдсан, харин 1,3 хувь нь сэргэлтгүй талхлагдсан бөгөөд тайлангийн суурь он буюу 2014 оныхтой харьцуулбал, бэлчээрийн талхлагдлын түвшин сүүлийн 2 жил өссөн дүнтэй, талхлагдаагүй болон сул талхлагдсан гэж ангилагдсан цэгийн тоо 10 хувь буурч, хүчтэй болон сэргэлтгүй талхлагдсан цэг 4,3-5,9 хувиар тус тус нэмэгдсэн гэж тогтоогджээ.

2002 онд батлагдсан Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлд “Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар 0,07 га-гаас илүүгүй, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 0,1 га-гаас илүүгүй газар үнэ төлбөргүй

эзэмшүүлж болно", "Багийн иргэдийн нийтийн хурлын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрийг үндэслэн, тариалангийн газрыг газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан Засгийн газраас тогтоосон журмын дагуу давуу эрхээр эзэмшүүлж болно. Нэг иргэнд давуу эрхээр эзэмшүүлэх тариалангийн газрын хэмжээ нь үр тарианы зориулалтаар 100 га хүртэл, төмс, хүнсний ногооны зориулалтаар 5 га хүртэл байна" гэж тус тус заасан байдаг.

Дээрх хуулийн заалтаас үзэхэд иргэнд төмс, хүнсний ногоо, таримал ургамалын зориулалтаар олгогдох газрын хэмжээ 0,1 га-гаас илүүгүй байх бөгөөд зөвхөн газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэн 0,1 га-гаас илүү хэмжээгээр үнэ төлбөргүй газар эзэмших эрхтэй байна. Өөрөөр хэлбэл иргэн газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажиллагаагүй бол 0,1 га-гаас илүү хэмжээгээр газар үнэ төлбөргүй эзэмших эрхгүй юм.

Мөн Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дах хэсэгт заасны дагуу атар газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглосон тул сум, орон нутгийн иргэдэд төмс, хүнсний ногоо, таримал ургамал тарих зориулалтаар эзэмшүүлэх эрх зүйн зохицуулалт нь учир дутагдалтай байна.

Хөдөө аж ахуйн газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бэлчээрийн доройтол, хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, иргэдийн амьдралын түвшинг сайжруулахын тулд энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрөөс 7 дугаар сарын 27-ны өдрүүдэд нийт 7 хоногийн хугацаанд томилолт аван өөрийн сонгогдсон тойрог болох Булган аймгийн 9 сум, 1 тосгонд ажиллан сумын өрхүүдээр нийт 10 удаагийн уулзалт хийж, 800 гаруй иргэд, сонгогчидтой уулзан саналыг авч, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Хэлэлцүүлгийн хүрээнд нийт 10 сумын 800 гаруй иргэдийн 60 хувь нь Газрын хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжсэн байна

2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр D.Parliament.mn сайтаар хуулийн төсөлд олон нийтээс санал авсан бөгөөд санал ирээгүй болно. Хуулийн төсөл батлагдсанаар зардал гарахгүй гэж үзэж байна.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлд дор дурдсан хэсэг нэмсүгэй.**

1. 29.4. Энэ хуулийн 52.7 заасан өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмшиж буй иргэн эзэмшлийн 1 га хүртлэх газартаа гэр бүлийн хэрэгцээнд зориулж төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тариалж болно.
2. 29.5 дахь хэсэгт "29.3" гэсний дараа "29.4" гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл. Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.**

1. 29.1. Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан нэг удаа үнэ төлбөргүй эзэмшүүлэх газрын хэмжээ хувийн гэр, орон сууцны зориулалтаар 0,07 га, өвөлжөө, хаваржааны зориулалтаар 1,5 га-аас тус тус илүүгүй байна."
2. 52.7. Өвөлжөө, хаваржааны доорхи газрыг Монгол Улсын иргэн гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа эзэмшиж болно.

**3 дугаар зүйл. Газрыг тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29.5, 29.6 дахь хэсгийн дугаарыг "29.5, 29.6, 29.7" гэж, мөн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэгт "29.5" гэж заасныг "29.6" гэж тус тус өөрчилсүгэй.**

**4 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтад "29.3" гэсний дараа "29.4" гэж, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтад "29.3" гэсний дараа "29.4" гэж, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэгт "29.3" гэсний дараа "29.4" гэж тус тус нэмсүгэй.**

**5 дугаар зүйл. Энэ хуулийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.**

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл. Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчилсүгэй.**

5.5. Энэ хуулийн 5.3 дахь хэсэгт заасан байгууллагын зөвшөөрөлгүйгээр Газрын тухай хуулийн 52.7 дахь хэсэгт зааснаас бусад атар газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно.

**2 дугаар зүйл. Энэ хуулийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.**

Гарын үсэг

## **ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДСАН ТУХАЙ ТАЙЛАН**

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"-ын дагуу Газрын тухай хуульд тандан судалгаа хийв.

Газрын тухай хуулиар зохицуулах харилцаа нь Хууль тогтоомжийн<sup>1</sup> хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах /цаашид "урьдчилан тандан судлах" гэх/ аргачлалын 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг тус Аргачлалын 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

### **Гарчиг**

#### **НЭГ. Асуудалд дүн шинжилгээ хийх**

##### **1.1. Асуудлын хамрах хүрээ**

Газрын тухай хуулийг боловсронгуй болгох бусад хууль тогтоомжид нийцүүлэн одоогийн хэрэгжиж буй хуулиа сайжруулах талаар судалгааг Үндэсний эрх зүйн баримт бичгүүдэд судалгаа шинжилгээг хийсэн.

Мөн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулахтай холбогдуулан мал аж ахуй эрхлэгчдэд хэлэлцүүлэг зохион байгуулж санал авч мал аж ахуй эрхлэгч нарын гаргасан санал, хүсэлт зэргийг судалж энэхүү судалгааг хийсэн болно.

Эрх зүйн зохицуулалтын талаар:

2002 онд батлагдсан Газрын тухай хуульд дараах зохицуулалт тусгасан:

Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлд "Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар 0,07 га-гаас илүүгүй, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 0,1 га-гаас илүүгүй газар үнэ төлбөргүй эзэмшүүлж болно", "Багийн иргэдийн нийтийн хурлын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрийг үндэслэн, тариалангийн газрыг газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан Засгийн газраас тогтоосон журмын дагуу давуу эрхээр эзэмшүүлж болно. Нэг иргэнд давуу эрхээр эзэмшүүлэх тариалангийн газрын хэмжээ нь үр тарианы зориулалтаар 100 га хүртэл, төмс, хүнсний ногооны зориулалтаар 5 га хүртэл байна" гэж тус тус заасан байдаг.

Дээрх хуулийн заалтаас үзэхэд иргэнд төмс, хүнсний ногоо, таримал ургамалын зориулалтаар олгогдох газрын хэмжээ 0,1 га-гаас илүүгүй байх бөгөөд зөвхөн газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэн 0,1 га-гаас илүү хэмжээгээр үнэ төлбөргүй газар эзэмших эрхтэй байна. Өөрөөр хэлбэл иргэн газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажиллагаагүй бол 0,1 га-гаас илүү хэмжээгээр газар үнэ төлбөргүй эзэмших эрхгүй юм.

Мөн Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дах хэсэгт заасны дагуу атар газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглосон тул сум, орон нутгийн иргэдэд төмс, хүнсний ногоо, таримал ургамал

---

<sup>1</sup>Монгол улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт.

тарих зориулалтаар эзэмшүүлэх эрх зүйн зохицуулалт нь учир дутагдалтай байна.

Газрын тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар энэхүү асуудлыг бүрэн шийдвэрлэх нөхцөл бүрдэх юм.

Иймээс Улсын Их хурлаас үүнтэй уялдуулан Газрын тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага бий болж байна.

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд

Одоогийн үйлчилж байгаа Газрын тухай хуульд малчин, тариаланчид хамаарч байна.

Эдгээр нь Монгол Улсын Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг мөрдөх бөгөөд тэдгээрийн эрх, ашиг сонирхол шууд хөндөгдөхгүй.

1.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

Тандан судлах ажлын хүрээнд газар, тариалангийн салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд гарч буй саад, бэрхшээлийг тус тус судалж, малчдын төлөөллийн дунд хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Иймээс судалгааны дүнг үндэслэж, Газрын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд, практик, дээр дурдсан бэрхшээлүүдэд тулгуурлаж хуулийг шинэчлэх зайлшгүй шаардлагатай байна гэж үзлээ.

### **ХОЁР. Асуудлыг шийдвэрлэх зорилго**

2.1. Гол зорилго, зорилт

Энэхүү үнэлгээний тайлангийн нэгд заасан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага урган гарч байгаатай холбогдуулан Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилт:

1. Газар, тариалангын салбарын эрх зүйн зохицуулалтыг нийгмийн хэрэгцээ, шаардлага болон нийгмийн харилцаанд үүсч болох улс төрийн ашиг сонирхлын зөрчил урьдчилан сэргийлэх, боловсролын асуудал эрхэлсэн байгууллага чадваржих, бие даан үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин бэхжүүлнэ.

2. Газрын тухай хуулийн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулийн агуулга, зарчимд нийцүүлэн уялдуулах.

**ГУРАВ. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн харьцуулалт**

3.1. Асуудлыг зохицуулах хувилбарууд

Энэхүү үнэлгээний тайлангийн Нэгд заасан асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу "зорилгод хүрэх байдал" буюу Үндсэн хуульд заасан Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлах эрхтэй нийцүүлж, чиг үүргээ хууль ёсны дагуу хэрэгжүүлэх нөхцөл бололцоог сайжруулах, хуулиар зохицуулаагүй харилцааг зохицуулах, хуулийн оновчгүй зохицуулалтаас үүдэлтэй бэрхшээлийг арилгах зорилгоор шийдлийг сонгох хувилбарыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь хэсэг, Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалд тус тус заасны дагуу Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль гэж үзэж байна.

Асуудалд дүн шинжилгээ хийх явцад хуулинд өөрчлөлт оруулахгүйгээр асуудлыг шийдвэрлэх гарцуудын талаар тодорхой судалгаанууд хийгдсэн.

- “Тэг” хувилбар буюу өөрчлөлт оруулахаас татгалзах. Энэ тохиолдолд өнөөгийн мөрдөж буй эрх зүйн зохицуулалтын хүрээнд ажиллахыг ойлгох бөгөөд одоогийн мөрдөж буй хуулийн зарим заалт хэрэгжихэд бусад хуультай зөрчилдөх, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа ба хуулийн зохицуулалтын хийлэл, зөрчилдөөн хэвээр байна.

- Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх. Одоогийн мөрдөж буй Газрын тухай хууль нь хэвлэл мэдээллээр хэрэгсэл, болон бусад хэрэгслээр авах боломжтой байна.

- Зах зээлийн механизмаар төрөөс зохицуулалт хийх. Малчин бизнесийн үйл ажиллагаа зах зээлийн механизмын дагуу явагдах боломжгүй бөгөөд Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Төр зохицуулалт хийх боломжтой.

- Төрөөс санхүүгийн интервенц хийх. Төрөөс санхүүгийн интервенц хийх буюу шууд мөнгөн хэлбэрийн дэмжлэг үзүүлэх аргаар зохицуулах боломжгүй юм.

- Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх. Монгол улсын Засгийн газрын тухай хуульд “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж болно...” гэж заасан байдаг боловч энэхүү харилцааг хуулийн төсөл боловсруулах хэлбэрээр зохицуулахаас өөр байдлаар зохицуулах боломжгүй.

- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах. Хууль тогтоомжийн тухай хуулийн 5.1-т заасны дагуу хуулийн өөрчлөлтийн төсөл боловсруулан хууль тогтоомжийн хоорондын уялдаа холбоо, хоорондын зөрчилдөөнийг арилгах зорилгоор хууль санаачлах замаар шийдвэрлэх боломжтой юм.

3.2. Зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулсан тухай Зорилгод хүрэх байдал: Зорилгод хүрэх байдлыг өмнө хийгдсэн судалгаа, санал асуулга, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдүүд болон салбарын мэргэжилтнүүдийн санал зэргийг үндэслэн тодорхойллоо.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт “Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлах эрхтэй” гэж заасны дагуу хаваржаа, өвөлжөөний газрыг эзэмшигч тухайн газраа төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар эзэмших боломжтой байх хууль зүйн шаардлагыг хангана.

Хуулийн төсөл батлагдсаны дараагаар эдийн засаг, нийгэм, хууль зүйн сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд улсын төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй.

3.3. Хамгийн үр дүнтэй хувилбарын тухай

Энэхүү тандан судалгааг хийх явцад зохицуулалтын нэг л хувилбар буюу хууль тогтоомжийн төслийг боловсруулах хувилбарыг сонгон авсан болно. Хууль

тогтоомжийн тухай хуулийн 5.1-т заасны дагуу хуулийн, өөрчлөлтийн төсөл боловсруулан хууль тогтоомжийн хоорондын уялда холбоо, хоорондын зөрчилдөөнийг арилгах зорилгоор хуульд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой үзсэн.

#### **ДӨРӨВ. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөний талаар**

Аргачлалын 5.5-т заасны дагуу хуулийн төсөл боловсруулах нэг хувилбарыг сонгосон ба үүнтэй холбогдуулан сонгосон нэг хувилбарын үр нөлөөг Аргачлалын 6-д заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

#### **4.1. Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө**

##### **4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйгийн 16.3 дахь хэсэгт "Хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлах эрхтэй" гэж заасны дагуу боловсруулав.

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа нь Аргачлалын 6.2-т заасан хүний эрхэд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /Хавсралт хүснэгт 1/-аас харагдаж байна.

##### **4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө**

Улсын төсөвт өөрчлөлт орохгүй бөгөөд бусад захиргааны байгууллага хуулийн этгээдэд ачаалал үүсгэхгүй нь Аргачлалын 6.2-т заасан эдийн засагт үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /Хавсралт хүснэгт 2/-оос харагдаж байна.

##### **4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө**

Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хувьд Аргачлалын 6.2-т заасан нийгэмд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /Хавсралт хүснэгт 3/-аас харахад нийгэмд үзүүлэх ямар нэг сөрөг үр нөлөө байхгүй ба төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид эерэгээр нөлөөлөхөөр байна.

##### **4.1.4. Байгаль орчинд үзүүлэх нөлөө**

Аргачлалын 6.2-т заасан байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /Хавсралт-4/-аас харахад хуулийн төсөл боловсруулах хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй байна.

**4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар**

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, зохицуулалтын хүрээнд нийцүүлэн хуулийн өөрчлөлтийн төсөл боловсруулагдсан болно.

Монгол Улсын Олон улсын гэрээний нийт 585 байх бөгөөд энэхүү хуулийн өөрчлөлтийн заалтын агуулга зөрчилдөн зүйл байхгүй болно.

**ТАВ. Тухайн зохицуулалтын талаархи олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулс: н судалгаа**

Аргачлалын 7-д зааснаар зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг харьцуулан дүгнэлт хийлээ. Үүнд:

---

#### **ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ**

Аргачлалын 9-д заасны дагуу энэхүү үнэлгээний тайлангийн 5 дахь хэсгийн "Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт", 6 дахь хэсгийн "Олон улсын болон бусад улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан



байдал” зэргийг харьцуулан Боловсролын тухай хуулийн нийгмийн хэрэгцээ, шаардлага болон Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлж, нийгмийн харилцаанд үүсч болох эрсдэл, боловсролын байгууллагын бие даан үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин бэхжүүлэх, сайжруулах зорилгын хүрээнд дараах зөвлөмжийг боловсрууллаа. Үүнд:

1. Газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын гндсэн хуулийн холбогдох заалттай агуулгын хүрээнд нийцүүлэн боловсруулах
2. Хуулийн төслийг зөвлөмжийн 1-т заасанд нийцүүлэн шинэчлэхдээ тухайн хуульд өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа харгалзан үзэх
3. Газрын тухай хуультай холбогдох Тариалангийн тухай хуулийг уялдуулан боловсруулах

#### Хавсралт-1

### 1. ХҮНИЙ ЭРХ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨНИЙ ТАНДАЛТЫН СУДАЛГАА

#### 1.1 ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Үгүй	Эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилготой арга хэмжээ биш болно.
	1.2.Оролцоог хангах		
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Малчин, тариаланчдын төлөөллийг оролцуулж хэлэлцүүлэг хийж, хуульд өөрчлөлт оруулах шаардлага байгаа эсэхийг тогтоосон. Оролцогчдын санал, хүсэлтийг хуулийн төсөлд зохих хэмжээнд тусгана.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх		
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага		
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Малчид уламжлалт мал аж ахуйгаа эрхлэхэд ахиц гарна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээнд аливаа байдлаар харшлаагүй бөгөөд хүний эрхийг хамгаалахад чиглэгдэж байна.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Хүний эрхийгхязгаарла сан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тоолсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Үгүй	
5.Жендэрийнэрх тэгш байдлыг	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Үгүй	Уг хуульд жендерийн эрх хөндөгдөхгүй болно.

хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Үгүй	Уг хуульд жендерийн эрх хөндөгдөхгүй болно.
-------------------------------------	---	------	---

### 1.2 ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3. Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4. Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3. Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4. Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээн.ий үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Үгүй	Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгохгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	

### 1.3 НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
---	------	--------------------------------

#### 1.4 БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй



	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

## **ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН**

### **НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Тариалангийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад тулгамдаж байгаа бэрхшээлийг шийдвэрлэх, хуулийн уялдаа холбоог хангах зорилгоор нийт 3 заалтыг хүчингүйд тооцсон.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

### **ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Практикт хэрэгжих боломж
4. Харилцан уялдаа зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэллээ.

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.

**“Практикт хэрэгжих боломж”** шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтооход туршилтын ажиллагааг явуулах цаг хугацааны боломж хомс байсан боловч хэлэлцүүлэг, судалгааны ажлуудаас гаргасан санал, зөвлөмжийг ашиглах замаар үнэлэх боломжтой гэж үзэн сонголоо.

**“Хүлээн зөвшөөрөгдөх байдал”** Хуулийн төсөл эцэслэн боловсруулагдаж холбогдох этгээдүүдээс санал авах үед аргачлалд заасны дагуу уг шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн холбогдох заалтуудыг үзэх боломжтой байх тул энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдэд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

**“Зардал”** шалгуур үзүүлэлтийн хүрээнд Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдан хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хир хэмжээний зардал үүсэх магадлалыг урьдчилан гаргах зорилготой. “Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” дэх зохицуулалтууд нь хуулийн этгээд болон иргэнд шинээр зардал үүсэхгүй болно.

**“Харилцан уялдаа”** шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Үндсэн хууль холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

## **ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

Энэхүү хэсэгт Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгов. Эдгээр зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдолтой, мөн анхаарах шаардлагатай заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл, тус хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ товч бөгөөд оновчтой байх үүднээс хуулийн төслөөс шинэлэг зохицуулалт бий болгож буй, агуулгын хувьд чухал ач холбогдолтой, мөн асуудалтай, анхаарах шаардлагатай заалтуудыг сонгож, тухайн сонгосон зүйл, заалтын үр нөлөөг судаллаа. Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцохоор сонгосон хэсгээ шалгуур үзүүлэлт тус бүрээр авч үзэв.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилт, зохицуулалтууд нь

нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилт, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ. Хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар:

№	Хуулийн төслийн хэрэгцээ шаардлага /хуулийн төслийн үзэл баримтлалаас/	Хуулийн төслийн зүйл, заалт
1	<p>2002 онд батлагдсан Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлд “Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар 0,07 га-гаас илүүгүй, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 0,1 га-гаас илүүгүй газар үнэ төлбөргүй эзэмшүүлж болно”, “Багийн иргэдийн нийтийн хурлын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрийг үндэслэн, тариалангийн газрыг газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан Засгийн газраас тогтоосон журмын дагуу давуу эрхээр эзэмшүүлж болно. Нэг иргэнд давуу эрхээр эзэмшүүлэх тариалангийн газрын хэмжээ нь үр тарианы зориулалтаар 100 га хүртэл, төмс, хүнсний ногооны зориулалтаар 5 га хүртэл байна” гэж тус тус заасан байдаг.</p> <p>Дээрх хуулийн заалтаас үзэхэд иргэнд төмс, хүнсний ногоо, таримал ургамалын зориулалтаар олгогдох газрын хэмжээ 0,1 га-гаас илүүгүй байх бөгөөд зөвхөн газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэн 0,1 га-гаас илүү хэмжээгээр үнэ төлбөргүй газар эзэмших эрхтэй байна. Өөрөөр хэлбэл иргэн газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажиллагаагүй бол 0,1 га-гаас илүү хэмжээгээр газар үнэ төлбөргүй эзэмших эрхгүй юм.</p>	<p>Газрын тухай хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулна.</p> <ol style="list-style-type: none"> <li>29.4. Өвөлжөө, хаваржааны газрын эзэмшигч нь өвөлжөө эсхүл хаваржааныхаа газраас 20᠒ метрийн радиус дотор гэр бүлийн хэрэгцээнд зориулан төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 1 га хүртэлх газрыг үнэ төлбөргүй эзэмшиж болно.</li> <li>29.5 дахь хэсэгт “29.3” гэсний дараа “29.4” гэж нэмсүгэй</li> <li>Газрыг тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 гэснийг 29.5, 29.5 гэсгийг 29.6, 29.6 гэсгийг 29.7 гэж өөрчилсүгэй.</li> </ol>
2	<p>Мөн Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дах хэсэгт заасны дагуу атар газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглосон тул сум, орон нутгийн иргэдэд төмс, хүнсний ногоо, таримал ургамал тарих зориулалтаар эзэмшүүлэх эрх зүйн зохицуулалт нь учир дутагдалтай байна.</p>	<p>Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийг дараах байдлаар өөрчилнө. “Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр Газрын тухай хуулийн 29.4 дэх хэсэгт зааснаас бусад атар газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно.”</p>

3.2. “Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

3.3. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараахь зохицуулалтыг сонгон үзлээ.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу боловсруулсан бөгөөд Өвөлжөө, хаваржааны газрын эзэмшигч нь өвөлжөө, хаваржааныхаа газраас 200 метрийн радиус дотор гэр бүлийн хэрэгцээнд зориулан төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 1 га хүртэлх газрыг үнэ төлбөргүй эзэмшиж болох зохицуулалтыг тусгалаа.

3.4. “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог тогтоохын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

### **ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараахь байдлаар харуулав.

<b>№</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>	<b>Үр нөлөөг үнэлэх хэсэг</b>	<b>Тохирох шалгах хэрэгсэл</b>
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Зорилгод дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төсөл бүхэлдээ	Практикт тухайн төрлийн харилцаанд гарч болох хүндрэлийг судлах.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах.

#### 4.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу боловсруулсан бөгөөд Өвөлжөө, хаваржааны газрын эзэмшигч нь өвөлжөө, хаваржааныхаа газраас 200 метрийн радиус дотор гэр бүлийн хэрэгцээнд зориулан төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 1 га хүртэлх газрыг үнэ төлбөргүй эзэмшиж болох зохицуулалтыг тусгалаа.

Мөн Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийг "Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр Газрын тухай хуулийн 29.4 дэх хэсэгт зааснаас бусад атар газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно" гэж өөрчилнө.

Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл шаардлага нь Хөдөө аж ахуйн газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулахын тулд өвөлжөө, хаваржааны газартаа иргэд төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих эрх зүйн орчин бий болгох юм.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл зорилгод нийцсэн байна. Гэхдээ практикт хэрэгжих боломжтой эсэхийг дараагийн шалгуур үзүүлэлтийн хүрээнд дахин авч үзэх болно.

#### 4.2. "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Газрын нэгдмэл сангийн 2021 оны улсын нэгдсэн тайланд дурдсанаар улсын хэмжээнд 80,033 га талбай бүхий өвөлжөө, хаваржааны газрыг 137,914 иргэн эзэмшиж байна. Эдгээр иргэд нь тухайн газрын байршил, газар зүйн онцлогоос хамаарч өвөлжөө, хаваржааны газрынхаа эргэн тойронд төмс, хүнсний ногоо, таримал ургамал тарих хүсэлтэй байдаг боловч газар эзэмшүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй тул боломжгүй байна.

2002 онд батлагдсан Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлд "Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар 0,07 га-гаас илүүгүй, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 0,1 га-гаас илүүгүй газар үнэ төлбөргүй эзэмшүүлж болно", "Багийн иргэдийн нийтийн хурлын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрийг үндэслэн, тариалангийн газрыг газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан Засгийн газраас тогтоосон журмын дагуу давуу эрхээр эзэмшүүлж болно. Нэг иргэнд давуу эрхээр эзэмшүүлэх тариалангийн газрын хэмжээ нь үр тарианы зориулалтаар 100 га хүртэл, төмс, хүнсний ногооны зориулалтаар 5 га хүртэл байна" гэж тус тус заасан байдаг.

Дээрх хуулийн заалтаас үзэхэд иргэнд төмс, хүнсний ногоо, таримал ургамалын зориулалтаар олгогдох газрын хэмжээ 0,1 га-гаас илүүгүй байх бөгөөд зөвхөн газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэн 0,1 га-гаас илүү хэмжээгээр үнэ төлбөргүй газар эзэмших эрхтэй байна. Өөрөөр хэлбэл иргэн газар тариалангийн салбарт олон жил тогтвортой

ажиллагаагүй бол 0,1 га-гаас илүү хэмжээгээр газар үнэ төлбөргүй эзэмших эрхгүй юм.

Мөн Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дах хэсэгт заасны дагуу атар газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглосон тул сум, орон нутгийн иргэдэд төмс, хүнсний ногоо, таримал ургамал тарих зориулалтаар эзэмшүүлэх эрх зүйн зохицуулалт нь учир дутагдалтай байна.

Газрын тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар энэхүү асуудлыг бүрэн шийдвэрлэх нөхцөл бүрдэх юм.

#### 4.3. "Ойлгомжтой байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтос лжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгасан бөгөөд үүнд хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн зохицуулалттай нийцэж байгаа, давхардаж байгаа эсэхийг "харилцан уялдаа холбоо" шалгуур үзүүлэлтийн хүрээнд шалгасан болно.

#### 4.4. "Харилцан уялдаа" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд

№	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Нийцэж байна.
2	Хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Газрын тухай хуулиар зохицуулах харилцаанд хамаарах хуулиуд байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Нийцэж байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт төслийн бусад заалттай нийцэж байгаа эсэх	Нийцэж байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт бусад хуулийн заалттай нийцсэн эсэх	Нийцэж байна
6	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Давхардсан зохицуулалт байхгүй



7	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төсөлд уг хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан.
8	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Орхигдуулсан зохицуулалт байхгүй
9	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төслөөр төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан зохицуулалт байхгүй.
10	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Хуулийн төсөлд төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх зохицуулалт байхгүй.
11	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Тухайн хуулийн төсөлд болон дагалдах хуулийн төслүүдээр татвар хураамж тогтоогоогүй.
12	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
13	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Хүнийг эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй
14	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
15	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
16	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
17	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хуулийн төсөлд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар тусгасан.

### ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үнэлгээний ажлын явцад хуулийн төслийн харилцан уялдаа, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийг батлан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох зорилгын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж,

уг асуудлын хүрээнд хийгдсэн судалгааг ашиглан дүн шинжилгээ хийх замаар хийж гүйцэтгэлээ.

Энэхүү хуулийн төсөлд Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу холбогдох судалгаа хийгдсэн тул энэхүү судалгааны дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлалыг дахин тодорхойлж, түүнд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

-----oO-----



УИХ-ын Гэсүүм  
Жадамбын БАТ-ЭРДЭНЭ



УИХ-ын Гэсүүм  
Лигэмын МӨНХБААТАР



УИХ-ын Гэсүүм  
Ганзоригийн ТЭМҮҮЛЭН



2022 ОНЫ 11 Р. САРЫН 7 ӨДӨР

УЛИАНБААТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ



✓ Дагах

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлд дор дурдсан хэсэг нэмсүгэй.

1. 1. 29.4. Өвөлжөө, хаваржааны газрын эзэмшигч нь өвөлжөө эсхүл хаваржааныхаа газраас 200 метрийн радиус дотор гэр бүлийн хэрэгцээнд зориулан төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 1 га хүртэлх газрыг зөвхөн нэг удаа үнэ төлбөргүй эзэмшиж болно.

2. 29.5 дахь хэсэгт "29.3" гэсний дараа "29.4" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Газрыг тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29.5, 29.6 дахь хэсгийн дугаарыг "29.5, 29.6, 29.7" гэж, мөн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэгт "29.5" гэж заалныг "29.6" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтад "29.3" гэсний дараа "29.4" гэж, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтад "29.3" гэсний дараа "29.4" гэж, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэгт "29.3" гэсний дараа "29.4" гэж тус тус нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ТӨСЛИЙН ФАЙЛУУД

## Гарсан санал хүсэлтийн товч жагсаалт

### БАЯННУУР СУМ – НАМЫН ГИШҮҮДТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТ 07/020

#### 1-р баг Д.Мягмарсүрэн

- Таны боловсруулсан хуулийн төслийг дэмжиж байна. Бид бүхэн өвөлжөө хаваржааны газартаа төмс, хүнсний ногоо тарьж өрхийн орлогоо нэмэгүүлээ гэхээр зөвшөөрөл байдаггүй. Зөвшөөрлийг нь хөөцөлдөө гэхээр атар газар хагалж болохгүй гэдэг шалтгаанаар тарьж, ургуулж болдоггүй. Яг одоо манай хөдөөгийн малчдад маш хэрэгтэй хуулийн төсөл юм.

#### иргэн Ганболд

- 30 жил зах зээлд ороод амьдрал маш хүндэрлээ. Мал гэж ярих юм. Махны үнэ тэнгэрт хадлаа. Идэж чадахгүй юм чинь мал өсгөх хэрэг байна уу? . Нам, ард түмэн минь гэж гарч ирдэг шүү та нар. Би олон жил бизнес хийсэн. Намайг харж үздэггүй. Тэтгэвэр, дунд насныхныг хардаггүй ээ. Ард түмний амьдрал сайжирсан уу. Яривал их юм бий. Би Бат-Эрдэнэ гишүүнийг магтаж явдаг. Ард түмнийхээ дотор ордог, шинэ хөдөө гээд яриад явдаг. Би гишүүндээ баярлаж явдаг. Шинэ хөдөө төсөл амжилттай хэрэгжсэн шиг энэхүү хуулийн төсөл батлагдаасай гэж хүсч байна.

### ГҮРВАНБУЛАГ СУМ 06/04 ТӨВ

#### Батмөнх Ахмадын холбоо

- Бат-Эрдэнэ дарга босоо тэнхлэгийн замыг нутагруугаа татан тавьсан. Үүнийг мэднээ. Энэ зам манай суманд их ач холбогдолтой. Замаа 4 жил үргэлжлүүлж дуусгаарай. Таны хийсэн ажилд бид баярлаж байдаг. Одоо харин газраа үр дүнтэй ашиглах, бэлчээрийг сайжруулах, малчдыг өрхийг амьжиргаагаа сайжруулахаар бодитой хуулийн төсөл бэлтгээд санал авч байгаад их баяртай байна. 200 метрын радиус гэдэг нь арай их биш үү. Бэлчээрийн хувьд манайд дутагдалтай байхад айл болгон газраа хашчихаар бэлчээргүй болох вч биш үү.

### ГҮРВАНБУЛАГ СУМ ХӨГНӨ БАГ

#### Батсайхан

- Би нэг юм захиж байсан. Өтөг түрчих юм. Энэ жил мал их үхлээ. Үүнийг ил хаявал өвчин гарч мэдэх юм. Үүнийг далдлах хэрэгтэй байна. Зам хаагуур явах вэ? Трактор тарааж өгсөн. Бид бүл багаар түрээслэн ажиллана. Бас худаг хэрэгтэй.

## **ГУРВАНБУЛАГ СУМ ХӨГНӨ БАГ**

### ***Мөнх-Эрдэнэ***

- Шинэ хөдөө төслөө үргэлжлүүлээрэй.

### ***Батболд***

- Шинэ хөдөө бол мал ахуйд оруулж байгаа хөрөнгө оруулалт гэж ойлгодог. Хойд сумдууд нь урд сумууддаа хадлан тэжээлээ борлуулж байх ажлыг шинэ хөдөө төсөлдөө тусгаарай. Оторын бүсэн дээр сайн бодлого барьж ажиллаарай.

## **МОГОД СУМ ТӨВ 07/21**

### ***Мөнхбайгал 2-р баг***

- Овсгоотой Булган нутагтаа мөнгө чирж ирдэг байгаасай. Хулгана их хэцүү байна. Хуучин устгаж байсан. Одоо харин хулганд хайр зарлаад байна. Байгалын хадлан авдаг давуу цаг ард хоцорлоо. Ашиглахгүй талбайгаа хашиж ногоон тэжээл авмаар байна. Тэжээлийн ургамал тарья. Удирдлагуудад хэлэхээр ойлгохгүй байна. Харин таны ийм хуулийн төсөл санаачилж байгаад их баяртай байна.

- .

## **Сайхан сум**

### ***Чадраабал***

- Архангай хайрхан, Сайхан сумын хилийн заагийг анхаарах, Хайрхан сум хилээ тэлээд байна. Манай 20-оод ИТХ-ынхэ т хэцүү байна. Бид шинэ хөдөө төслөөр ирсэн юмыг мэдэхгүй байна. Удирдалгууд баллаад байна. Луулийн төсөл нь их сайхан сонсогдрж байна. Гэтэл удирдлагуудын тал дээр учир дутагдалтай байна.

## **Сайхан Овоо, Хульж баг**

- Шинэ хөдөө төслийг мэдэхгүй байна. Бухыг гунжтай нь авчирвал сайна байна. УИХ-д гарахаараа дарлагддаг. Үүнд анхааралтай хандаарай. Таны хэрэгжүүлсэн олон сайхан төсөл сумын удирдлагууд дээр ирээд байхгүй болдог юм.

## **Баян-Агт сумын төв**

### ***Батмөнх***

- Ахмадуудыг харах хүнгүй болж байна. Үүнд анхаарч ажиллана уу. Шинэ хөдөө хөтөлбөрөө үргэлжлүүлээрэй.

### ***Залуу***

- Эр хүний жудгаар төрийн сайдаа өгч байсанд би талархаж явдаг шүү. Шинэ хөдөө төслийг дэмжиж байдаг шүү. Одоо хоёулаа хамтраад маш хүчтэй ажиллаарай

### ***Нямбаяр***

- Би эрчимжсэн мал аж ахуйг сонирхдог. Би Сэлэнгэ аймаг дахь Ж.Энхбаярын хийсэн ажлыг үзлээ. Бэлчээрийн асуудлыг шийдсэн байна. Хадлангийн талбайг их анхаарч ажиллаарай. Шаргад ирсэн бухыг ямар айл авсан бэ? Ирсэн зүйлээ хоорондоо ярьж байгаад хуваамаар байна.

### ***Дамдинсүрэн***

- Газар тариалан эрхэлж байгаа бүх сумдад туслах. Газар тариалангийн хуульд өөрчлөлт оруулах. Бэлчээрийн даац хэтэрсэн. Тэжээлийн талбайтай больё. Газар тариалан эрхэлдэг компани сумандаа ээлгүй байна. Тэжээл тарих хэрэгтэй. Тэжээл авах гэж олон цаг зардаг. Сум орох замыг бодолцоорой

## **Баян-Агт сум, Баянхайрхан баг**

### ***Нармандах***

- Мал олон болсон, Бэлчээр муудлаа. Малынхаа чанарыг сайжруулж, цөөлөх хэрэгтэй байна.
- Отор нүүдлийн газаргүй боллоо.

### ***Данзанжамц:***

- Залуучуудаа дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлээрэй.
- Төсөл далд шалгаруулагддаг. Төсөл нүдээ олж очиж уу гэдгийг шалгаж байгаарай.
- Төсөл нэг хүний хэрэглээ болоод байна шүү.
- Ногоон тэжээл шаардлагатай байна.
- Малчдынхаа үгийг сонсдог багийн даргатай болмоор байна.

## **Хутаг-Өндөр сум,**

### **Санжаажав:**

- Мал аж ахуйг дэмжсэн шинэ хөдөө төслөө үргэлжлүүлээрэй.
- Мал хамгаалах нийгэмлэгийг үйл ажиллагааг их дэмжиж байна.
- Суманд ихэнх талбайд тариа тарьчихсан байдаг. Үүнд бодлого барих хэрэгтэй.
- Газар тариалангийн хуулийг харж өөрчлөх

### **Тэшиг, Харгал баг**

#### **Пунцаг:**

- Тэшигийн 70 км замыг тавих хэрэгтэй. Манай тэшиг сум газар тариалан ихтэй, ойн сан бүхий газар. 200 метрын радиус дотор гэдэг их бага байна. Жишээ нь манай өвөлжөө модон дотор байдаг. Хэрвээ юм тарья гэвэл 200-аар метрын цаана тарих хэрэгтэй болно.

#### **Оюун:**

- Өрхийн үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Тэтгэврийн доод хэмжээг 500 мянга болгох
- .

#### **Тэшиг,**

#### **Мөнхөө:**

- Илэнх хүртэл зам тавибал байгаль орчинд сөргөөр нөлөөлнө. Үүнийг хамгаалах юм байх хэрэгтэй.
- Буриад зон цөөрч байна. Шилжсээр байгаад дууслаа. Энэ нутгийн амьдрал ахуйг анхаарч үзэх цаг болсон.
- Модны үнэ өндөр байна. Модонд дунд байж модоо ашиглаж чадахгүй байна.
- Багийн төвийг тохижуулах
- Багийн эмнэлэгтэй болох
- Буриадын өв соёл хаягдаж байна.
- Шинэ хөдөө төслөө энэ нутагт хэрэгжүүлээч ээ. Би өөрөө хариуцъя.

**Бугат, Цогтсайхан:**

- Газар олголт төвөгтэй байна. Ийм төвөгтэй байхад засаг дарга нарт бүр их эрх мэдэл олгож байгаа юм бишүү. Хуулийн төслийг дэмжиж байна.

**Сэлэнгэ сум**

**Чанцал:**

- Тариаланчдаа илүү анхаараад байна аа.

**Сэлэнгэ, сумын төв**

**Бямбасүрэн:**

- Шинэ тавьсан гүүр дундуураа 2 салаа, үүнийг засах

**Сэлэнгэ, 2 дугаар баг**

**Иргэн:**

- Арьс шир боловсруулах техник хаана байна аа.
- Сүүний танкыг ашиглахгүй байна.

**Хишигсүрэн:**

- Тусгай хамгаалалтын газар малчдын газар дээр ороод ирсэн. Малд торгууль тавигдаад байна.
- Ноос, ноолуурын асуудал хүнд байна.
- 1000 үнээнд 1 бух боломжтой юу?

**Цоодол:**

- Хилийн заагийг шийдэж өгөөч ээ. 1976 оноос хойш ийм байна.

**Иргэн:**

- Бэлчээрийн даац муудлаа.
- Азаргын голд зам засах
- Арьс шир боловсруулах машин

**Иргэн:**

- Сум хуулийн хүрээнд тариалангийн бус нутаг болсон. Бид үүнийг эсэргүүцэж байна.



**Хангал,**

**Энхболд:**

- Газар нутаг шийдэхгүйгээр Хялганат хөгжихгүй.
- Хангал, хялганат, Сэлэнгийн Засаг дарга нар 3 тийш хараад сууж байхад энэ шийдэгдэхгүй. Бидэнд газар авах гээд авах газар байхгүй.
- Хялганат гэсэн жижиг хөтөлбөр боловсруулж, ажилтай болгон, шинэ үйлдвэр барих хэрэгтэй байна.
- Дотуур байрны барилга барих

**Хангал,**

**Энх-Эрдэнэ:**

- Ногоо тарихад трактор хэрэгтэй.

**Даваажав:**

- Хаягдал мод ашиглах
- Ерөөд яригдаж байгаа сайн үүлдрийн хонийг авч сүргээ сэлбэх

**Батсайхан:**

- Малын түүхий эдийг боловсруулах, арьс ширний үйлдвэр байгуулах нь чухал шүү.

**Дашинчилэн сумын төв**

**Иргэн:**

- Ахмадуудаа алагчлахгүй байх, авсан нь зол, аваагүй нь хохь гээд орхисон . Хамтын тэтгэвэр бий болгох,
- Архидан согтуурахтай тууштай тэмцэх

**Дашинчилэн сум, Лах баг 2 адуу бэлэглэсэн.**


**Сүхбаатар:**

- Бэлчээрийн тухай хууль байж болох уу
- Отрын бүс нутгийг буулгах,
- Эрчимжсэн бал аж ахуй чухал байна.

**Бадамсүрэн:**

- Монгол эзэнтэй, монгол ажилчинтай махны үйлдвэр байгуулах

Түүвэрлэж бичсэн.....Б.Батболд

A handwritten signature in black ink, consisting of several overlapping loops and a long horizontal stroke at the top, positioned over the text "Түүвэрлэж бичсэн.....Б.Батболд".